



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗАВХАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Дугаар: 06

Улиастай сум
2025 он

Агуулга

1. Танилцуулга

2. Аудитын зорилго цар хүрээ

Аудитын зорилго.....

Аудит хамрах хүрээ, хязгаарлалт.....

Дотоод аудитын арга, аргачлал

3. Байгууллагын сайн туршлага

Байгууллагын талаар.....

Байгууллагын засаглал

Эрсдэл удирдлага.....

Дотоод хяналтын систем, шилэн дансны мэдээлэл.....

4. Санхүү аж ахуйн үйл ажиллагааны талаар

Аудитад хамрагдсан хугацааны хуулийн этгээдийн бүртгэл, харилцах дансны

мэдээлэл, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах эрх

Өмнө хийгдсэн шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, биелэлт.....

Орлого, зарцуулалт хөрөнгийн ашиглалт хамгаалалт

5. Аудитаар илэрсэн зөрчил, төлбөр аудитын үр дүн

6. Нэгдсэн дүгнэлт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДА-СХШУАБ	Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
ДА-СХШУБ	Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч
ТАХХ	Төрийн алба хаасан хугацаа
ХБӨ	Халдварт бус өвчин
ЭМС	Эрүүл мэндийн сайд
КМ	Километр
ХХК	Хариуцлагатай хувьцаад компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

1.ТАНИЛЦУУЛГА

Албаны 2025 оны дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу даргын 2025 оны 02 сарын 06-ны өдрийн 02 дугаар удирдамжаар Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын 2023, 2024 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд ДА-СХШУАБ Т.Цэрэндолгор, ДА-СХШУБ Б.Үүрийнтуяа нар 2025 оны 02 сарын 10-ны өдрөөс 03 сарын 17-н хүртэлх хугацаанд дотоод аудит хийж гүйцэтгэв.

2.АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Орлого төвлөрүүлэлт, зарцуулалт, үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт үр дүн

Бүтэц орон тоог зохистой төлөвлөж удирдлагын менежментийн үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

Иргэн аж ахуй нэгж байгууллагуудтай байгуулсан гэрээний үр дүн

Өр, авлага үүссэн бол шалтгаан нөхцөлийг тогтоох

Цалин тогтоолт, олголт, хүний нөөцийн бодлого

Монгол улсын хууль, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал болон бусад холбогдох хуулийн хэрэгжилт

Бусад асуудлууд

Аудитын явцад хамрагдаагүй, хязгаарлагдсан асуудал байхгүй болно.

2.3 Аудитын арга аргачлал

Аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно.

Аудитын асуудлуудын хамрах хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад тулгуурлан дүн шинжилгээ хийж, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно.

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Байгууллагын талаар

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, нотолгоонд суурилсан оношилогоо, эмчилгээний шинэ техник, технологийг нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгаж амьдралын чанарыг сайжруулахад оршино.

2023, 2024 онд 36 хүний бүтэц орон тоотойгоор төрийн үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаагаа явуулсан байна. Албан хаагчдын 36 нь буюу 98,4 хувь нь дээд боловсролтой, Төрийн захиргааны албан хаагч 18, Төрийн үйлчилгээний албан хаагч

20 нийт 38 албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулан иржээ. Үүнээс магистрын зэрэгтэй 12 албан хаагчтай.

Тус газрын дарга, албаны дарга, хүний нөөцийн дотоод ажил, мэргэжилтнүүд, үйлчилгээний болон гэрээт ажилтан гэсэн байдлаар аймгийн Засаг даргад ажлаа шууд хариуцан тайлагнан ажилдаг байна.

3.2 Байгууллагын засаглалын талаар

Тус газрын дарга нь аймгийн Засаг даргад ажлаа шууд хариуцан тайлагнан ажилладаг.

3.3 Эрсдэлийн удирдлагын талаар

Тухайн байгууллага нь санхүүгийн чиглэлээр эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийн бүртгэл байхгүй, байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт чиг хандлага, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрд байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж үнэлээгүй байна.

3.4 Дотоод хяналтын талаар, шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 02 сарын 01-ны А/03 дугаар тушаалаар эмнэлэгийн тусламж үйлчилгээний хэлтсийн чанарын мэргэжилтэн П.Оюунсүвдаар ахлуулсан дотоод хяналтын ажлын хэсгийг байгуулж, тус тогтоолын дагуу дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулсан боловч хагас, бүтэн жилээр дотоод хяналтыг хийж холбогдох албан хаагчдад заавар зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажилчдадаа танилцуулсан бичиг баримт байхгүй.

3.5 Шилэн дансны хэрэгжилт:

2023 онд шилэн дансны цахим хуудсанд нийт 171 мэдээлэл байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд нь 1 мэдээллийг хоцроосон, 12 мэдээлэл оруулаагүй, 2024 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас 170 мэдээллийг хугацаанд нь 1 мэдээллийг хоцроож байршуулсан үзүүлэлттэй байна.

4. САНХҮҮ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Аудитад хамрагдсан хугацааны хуулийн этгээдийн бүртгэл, харилцах дансны мэдээлэл, хөрөнгө мөнгө захиран зарцуулах эрх

Тухайн байгууллага нь 2023, 2024 онд улсын бүртгэлийн 9039597 регистрийн дугаартай үндсэн үйл ажиллагааны Төрийн сан дахь 100090013001, нэмэлт санхүүжилтийн 100090013401 дугаар бүхий харилцах данстай. 2023, 2024 онд хөрөнгө зарцуулах эрхийн 1-р гарын үсгийг дарга М.Үржинханд, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Д.Чимэддолгор, З.Саранчимэг, П.Номинзул нар зурж хөрөнгийг зарцуулсан.

4.2 Өмнө хийгдсэн шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, биелэлт

Баталгаажуулаагүй томилолтын хуудсаар томилолт олгосон, ажлын хөлс болон ХХОАТ суутган тооцоогүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр тандалтын багийнханд 2022 оны 1 дүгээр улирлын урамшууллыг илүү тооцож олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, албан хаагчдаар төлүүлэх актын төлбөрийг төсвөөс

төлсөн, төсвийн хөрөнгөөр ажилчдад хувцас худалдан авсан, ТАХ-ын нэмэгдэл, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл, хоолны хөнгөлөлтийг илүү олгосон зэрэг зөрчлүүдтэй холбоотой 14952,8 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосноос 13263,8 мянган төгрөгийг барагдуулж 1689,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тус шалгалтаар Санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ авах, дотоод хяналтын нэгж хангалтгүй, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын бүртгэлтэй машинд шатахуун хийж албан ажилд шатахуун зарцуулах, тухайн ажилтанд шатахуун олгохдоо хийсэн ажлын тайлан бичүүлж, шатахууны зарцуулалтын тооцоог хийж илүү, дутууг тооцож байх, замын хуудсыг стандартын дагуу бодитой бичүүлэх зэрэг чиглэлийг өгч ажилласан байхад 2023, 2024 онуудад энэхүү зөрчил давтан гарсаар байна.

2023 онд Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б. Мөнхнасан жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулалтын аудитаар өөрчлөлтгүй, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сүлд аудит ХХК-ны аудитор Ц.Алтантуул баталгаажуулж "Өөрчлөлтгүй дүгнэлт" өгсөн. 2024 оны баталгаажуулах аудитаар нийгмийн даатгалын шимтгэл тасарсан 2 албан хаагчид Хөдөө орон нутагт ажилласны тэтгэмж 14208,0 мянган төгрөгийг олгосон, төрийн хэмнэлтийн хууль зөрчин заалны төлбөр 400,0 мянган төгрөг, спортын арга хэмжээнд 2280,0 мянган төгрөг зарцуулсан нийт 16888,0 мянган төгрөг нөхөн төлбөр тогтоосон байна.

4.3 Орлого, зарцуулалт, гүйцэтгэлийн талаар Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөгөөр/

Орлогын нэр	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Үзүүлэлт						
Улсын төсвөөс	2938525200	2930539635	459755911	2930539635	4890323848	
Орон нутгийн төсвөөс		492467271		492467271	705444936	
ҮҮА орлого					11295000	
Төвлөрүүлсэн		24718300				
Дүн		3398288606			5607063784	

Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөгөөр/

Зарлагын нэр	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1078286800	1566095712	487808912	1031590200	1040175742	8585541.59
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101006400	102516516	1510116	128936300	114357700	14578600
Байр ашиглалтай холбоотой зардал	64928300	64871252	57047	80499500	79933544.32	565955.68
Хангамж бараа материал	25076400	24511364	565035	81957700	95391335.34	13433635.34
Нормативт зардал	2017600	1601900	415700	3206000	1306300	1899700

Эд хогшил худалдан авах	27413200	29471200	2058000	57718000	56877190	840810
Томилолт зочны зардал	20858700	20705900	152800	38258700	37831000	427700
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	6052300	6019224	33076	5533900	7641440	2107540
Бараа үйлчилгээний бусад зардал	27582800	516734087	489151287	38339400	123778965	85439565
Бусад урсгал шилжүүлэг	1860238400	1832185399	28053001	1856911193	3848515925	571763569

2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 411288.8 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй 492467.3 мянган төгрөгийн зардалтай ажилснаас сайн эмч болон бусад төсөл арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

2024 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 3071,8 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 627,7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, үйл ажиллагаандаа зарцуулсан.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсөл хөтөлбөрийн үр дүн

Аймгийн засаг даргын 2023 оны хөгжлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2021 оны А/264 дүгээр захирамжаар “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд 6182,6 мянган төгрөгийг шалгарсан эмч нарыг урамшуулсан.

Эрүүл мэндийн яамнаас “Элэг бүтэн арга хэмжээний хүрээнд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мэргэжилтэнүүдийг чадавхижуулах сургалт арга хэмжээний хүрээнд 60000,0 мянган төгрөгийг зарцуулсан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өвөлжилт хүндэрсэн сумдад тусламж үзүүлэх, эмч нарын томилолт, шатахууны зардалд 25400,0 мянган төгрөгийг зарцуулсан.

2024 онд Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/86 “Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн сумын эрүүл мэндийн төвүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх” тухай тушаалаар Улиастайгаас бусад 22 сумдад 1000,0-2000,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн

Аймгийн Засаг даргын А/30 захирамжаар хуваарилагдсан 10000,0 мянган төгрөгийн санхүүжилтээр албан хаагчдаа урамшуулсан /шилдэг агентлаг болсон/

“Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд 14000,0 мянган төгрөгөөр шалгарсан эмч нарыг урамшуулсан

Эрдэм шинжилгээ, судалгааны хурал зохион байгуулж шагнал, батламжийн зардалд 10000,0 мянган төгрөгийг зарцуулсан

Эх, хүүхдийн эрүүл мэнд, яаралтай тусламж, халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулахад сургалтын төлбөр, замын зардал, бичиг хэргийн зардалд 10000,0 мянган төгрөгийг зарцуулсан

Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй харилцаа, хандлагыг сайжруулахад сургалт, томилолтын зардалд 4000,0 мянган төгрөгийг зарцуулсан

Цусны донорын өдөрт 2000,0 мянган төгрөг зарцуулсан

Сэтгүүлд эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл хэвлүүлэхэд 10000,0 мянган төгрөг зарцуулсан

Баруун бүсийн зөвлөгөөнд шатахуун, анонс, бичиг хэрэг зэрэгт 20000,0 мянган төгрөг зарцуулсан

Өсвөр насныхны дунд зарим ХБӨ тархалт, оношлогоо, эмчилгээ хяналт төслийг хэрэгжүүлэхэд томилолт, шатахууны зардалд 10000,0 мянган төгрөгийг зарцуулсан

Нялхас, бага насны хүүхдийн хооллолтыг гамшгийн үеийн арга хэмжээтэй уялдуулах нь сургалт, хяналт үнэлгээ хийхэд сургалтын зардал, багшийн хөлс, байр, зам зардал зэрэгт 10000,0 мянган төгрөг зарцуулсан

Дэмжлэгт хяналт хийх мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд томилолт, шатахуун, хөлс олгосон зардалд 4606,7 мянган төгрөг зарцуулсан

ЭМСайдын А/177-р тушаалаар эрүүл мэндийн сургалт зохион байгуулж 25580,0 мянган төгрөг зарцуулсан

Аймгийн Засаг даргын А/181 захирамжаар хуваарилагдсан 9810,0 мянган төгрөгийн санхүүжилтийг сумдад шилжүүлсэн /эрт илрүүлэг/

Чадварлаг эмч хөтөлбөрийн хүрээнд 21 албан хаагчид хорь, хорин сая төгрөг буюу нийт 420,0 сая төгрөгийг олгосон

"United nations childrens fund" байгууллагын санхүүжилтээр "стретококк" сургалтын зохион байгуулж багшийн хөлс, томилолт, шатахууны зардалд 24516,9 мянган төгрөг мөн ПВирус сургалтад 50799,6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

5. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТӨЛБӨР, АУДИТЫН ҮР ДҮН

5.1 Аудитаар илэрсэн зөрчил:

2023 он

Бараа үйлчилгээний /210901/ зардлаас Завхан толь сонин хэвлэлийн төлбөр шилжүүлсэн

Загасан нүд загастай ХХК-д удирдах ажилтны зөвөлгөөний хоолны зардал, БАТТМАХ ХХК-д ЭМ-ийн салбарын ажилчдын удирдах ажилтны зөвөлгөөний хоолны зардлуудыг гаргасан байна.

Далууд ХХК-аас бичиг хэрэг, тээвэр шатахуун, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, принтерийн хор, цэвэрлэгээний материал гэх мэт нийт 13994,9 мянган төгрөгийн зардлыг шилжүүлсэн байна.

2024 оны 01 сард Доной явсан 70 км, 5 сард Цагаанчулуут сум, Отгонтэнгэрийн амралт явсан 400 км, 6 сард хот дотор 50 км явсан замын хуудсыг эрх бүхий албан тушаалтан баталгаажуулаагүй /шаардах хуудасгүй/

Эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байхад урамшуулал /балансын/-ыг урьдчилан авсан

Нягтлан бодогч /П.Номинзул/ шийдвэргүй ур чадварын нэмэгдэл авсан

Өмнөх оны илүү цагийг 2024 онд тооцоо гарган авсан

Цалинтай чөлөө авсан албан хаагчид унаа хоолны мөнгийг олгосон

Баяр ёслол, бүх нийтийн амралтаар ажиллаагүй байхад илүү цагийн

нэмэгдлийг 2%-аар тооцолж олгосон

Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын цахим системд тайлагнахдаа 3994560.44 төгрөгийг дутуу тайлагнасан /966683.6 төгрөгийн шимтгэл төлөгдөөгүй орхигдсон/

2023 онд 947662.26 төгрөг, 2024 онд 16328193.94 төгрөг нийт 17275856.2 төгрөгийн авлага үүсгэж нийгмийн даатгал руу шилжүүлсэн

2024 онд цалингаас суутгасан ХХОАТ-ыг 4396342.16 төгрөгөөр илүү төлсөн боловч жилийн эцсээр 665841.31 төгрөгийн авлага тусгасан /тооцоо нийлсэн актаар/ 2023 онд 3730500.85 төгрөгийн дутуу төлөлттэй байсан гэх ба тооцоо нийлсэн акт байхгүй, санхүүгийн тайланд тусгаагүй

Ээлжийн амралт, үндсэн цалинг давхардуулан авсан

Улирлын үр дүнгийн урамшууллыг шийдвэргүй болон илүү авсан зөрчлүүд байна. Эргээд зөрчлүүдтэй холбоотой 21051,1 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

5.2 Төлбөр:

2023 он

Иргэн Д.Нямцэрэнгээс сувилахуйн сургалтын зардлаас ундаа, ус худалдан авсан, төсвийн хөрөнгөөр ааруул, еэвэн, чихэр,самар печень зэргийг төсвөөс худалдан авч зориулалт бус зардал гаргасан.

Үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлсийг илүү тооцож олгосон.

Шатахууныг явсан ажлын тайлангүй, жолоочийн тооцооны хуудасгүй, дуудсан бичиггүй албан бусаар зарцуулсан зэрэг зөрчилд 6 510,9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон ажиллалаа.

2024 он

Шийдвэргүй үр чадварын нэмэгдэл авсан, НДШ, ХХОАТ-ыг илүү төлж авлага үүсгэсэн төсөвт төвлөрүүлээгүй, илүү цагийн нэмэгдлийг буруу тооцоолсон, ээлжийн амралтын мөнгийг илүү тооцоолж авсан, шатахууныг зориулалт бусаар зарцуулсан зэрэг 21 051,4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон ажиллалаа.

5.3 Аудитын үр дүн:

Илэрсэн асуудал 1	Авлага үүсгэж ажилласан
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: 2023 оны жилийн эцсээс эхлэн 2024 оны жилийн эцэст НДШ-ийг 17275856,2, ХХОАТ-ыг 665841,3 төгрөгөөр илүү төлж авлага үүсгэсэн	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулан өглөг, авлага үүсгэхгүй байх. Төсөв хэмнэгдсэн тохиолдолд жилийн эцэст буцаан төвлөрүүлэх	
Асуудлын үндсэн шалтгаан:Хяналт муу	
Байгууллагад үзүүлэх нөлөө:Жилийн эцсээр урьдчилан төлсөн авлага нь нөхөн төлбөрийн акт тогтоогдох, дараа оны төсөвт хэмнэлт үүсвэл үр ашиггүй үрэлгэн зарцуулах эрсдэлтэй	
Зөвлөмж: "Төсвийн тухай" хуулийн 6-р зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"	

Илэрсэн асуудал 2	Төсвийн зориулалт бус зардал гаргасан, зардлын зарцуулалтыг тайлагнаагүй
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: 2023 онд иргэн Д.Нямцэндээс сувилахуйн сургалтын зардлаас ундаа, ус худалдан авсан, төсвийн хөрөнгөөр ааруул, еэвэн, чихэр, самар, печень зэргийг худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан 759,5 мянган төгрөг	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулалтын тайланг үнэн зөв бүртгэлд тусгах	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналтын нэгжийг хараат бус байлгах зарчмаар байгуулаагүй, төсөв санхүүтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагаандаа хандуулаагүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө: Байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулах	
Зөвлөмж: ТТХ 6.4.1, ТТХ 16.5.5, НББТХ 13.7 Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, Бадлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно гэсэн хуулийн заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллах	

Илэрсэн асуудал 3	Шатахууныг зориулалт бусаар, явсан ажлын тайлангүй амралтын өдрүүдэд зарцуулсан
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: 2023, 2024 онд 917,6 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар зарцуулсан	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Тухайн ажилтанд болон албан тушаалтанд шатахуун олгохдоо хийсэн ажлын тайлан бичүүлж, шатахууны зарцуулалтын тооцоог хийж илүү, дутууг тооцдог байх, албан ажлаар явсан байдлыг нотлох баримт цуглуулах	
Асуудлын үндсэн шалтгаан: Амралтын хагас бүтэн сайн өдөр, бүх нийтээр амрах өдрүүдэд ажил гүйцэтгэсэн мэтээр албан бусаар шатахуун зарцуулсан, албан тушаалаа ашиглан төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байх магадлалтай	
Байгууллагад үзүүлэх нөлөө: Байгууллагын төсөвт хохиролтой	
Зөвлөмж: ТТХ 6.4.1, ТТХ 16.5.5, НББТХ 13.7 хуулийн хүрээнд шатахууны зардлыг зөв зохистой удирдан зарцуулах	

6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, эрсдэлийн удирдлага хангалтгүй байгаа тул эрсдэлийн үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах.

Дотоод хяналтын нэгжийг хараат бус байлгах зарчмаар байгуулан, төсөв санхүүтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагаандаа хандуулах.

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн үр дүнгүй, үрэлгэн, зориулалт бус зардал гаргахгүй байх

Шатахуун зарцуулахдаа явсан ажлын тайлан бичиж зардлын үр дүнг тооцож, сар бүр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх

Конторын барилгын болон машин засварын ажлыг бусдаар гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулдаг байх

байгууллагын техникийн комиссоор дүгнэлт гаргуулан сэлбэг хэрэгсэл худалдан авах

Актын төлбөрийг хугацаанд нь барагдуулах

Тайлан бэлтгэсэн:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны

ДА-СХШУАБ

Т.Цэрэндолгор

ДА-СХШУБ

Б.Үүрийнтуяа

Танилцсан:

Эрүүл мэндийн газрын:
дарга

М.Үржинханд

Нягтлан бодогч

Л.Ганчимэг

Эдийн засагч

З.Саранчимэг

